



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 1167.

Улаанбаатар хот

Нийгмийн эрүүл мэндийг дэмжих  
хөтөлбөр батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.2 /ж/ дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 20.1.14 дэх заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, 2017 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг дүүргийн төсөвт тусган, биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнан ажиллахыг дүүргийн Засаг дарга /Ж.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.



Б.МӨНХЦЭЦЭГ



## НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг Үндэслэл

Монгол Улсын нийгэм-эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн дэвшил шилжилт хөдөлгөөн, хотжилт, өсөхийн зэрэгцээ хүрээлэн байгаа орчны бохирдол, иргэдийн буруу зан үйл, дадал хэвшил нь хүн амын эрүүл мэнд, сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж байна.

Хүн амын дунд буруу хооллолт, аюулгүй хүнсний хэрэглээ, хөдөлгөөний хомсдол, хорт зуршил, сэтгэл хөдлөлөө хянах, илэрхийлэх аргад суралцахгүй, хувийн ариун цэвэр сахидаггүй нь зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчин нэмэгдэхэд нөлөөлж байна.

Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан ундны цэвэр усны хангалт хэрэгцээгээ гүйцэддэггүй, халуун усны газар хүрэлцээгүй, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдийн гар угаах, бие засах газар орчин үеийн шаардлагад хүрээгүй, өрхийн эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл сургалт сурталчилгаа хангалтгүй, зорилтод бүлэгтээ хүрэх нөхцөл бүрдээгүй байсаар байна.

Сонгинохайрхан дүүргийн Эрүүл Мэндийн Төвийн сүүлийн 3 жилийн эрүүл мэндийн үзүүлэлтээр бэлгийн замаар дамжих халдварт өвчин 5.9-24.6 хувиар нэмэгдсэн дүнтэй гарлаа.



Дээрх графикаас харахад тэмбүү, сүрьеэгийн тохиолдол жил ирэх тусам нэмэгдэж байна. Ойролцоо хүн амтай Баянзүрх дүүрэгтэй харьцуулахад халдварт өвчний дэгдэлт өндөр байна.

Сонгинохайрхан дүүргийн сүүлийн 5 жилийн амбулаторийн үзүүлэлтээс харахад хүн амын нас баралтын шалтгаанд халдварт бус өвчин зонхилох байр суурьтай байгаа болно. Үүнд

- Цусны эргэлтийн тогтолцооны өвчин
- Хавдар
- Хоол боловсруулах замын өвчин
- Амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин гэх мэт өвчнүүд орж байна.


Хорт хавдраар өвчлөгсдийн 70 гаруй хувь нь 3-4 дүгээр үедээ буюу хожуу оношлогдсоноос тухайн жилдээ нас барах тохиолдох элбэг байна.

Сонгинохайрхан дүүргийн өвчлөлийн сүүлийн 5 жилийн статистикийг харвал

	Онош	2012	2013	2014	2015	2016	дундаж	байр
1	Халдварт ба шимэгчит	2.5	1.7	2.4	1.5	1.7	2.0	
2	Хавдар	30.6	32.8	34.3	36.9	40.6	35.0	II
3	Цус, цус бүтээх эрхтэн	0.0	0.0	0.0	0.1	0.0	0.0	
4	Дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцоо	1.5	1.5	2.9	1.5	2.0	1.9	
5	Сэтгэц	0.0	0.0	0.3	0.2	0.5	0.2	
6	Мэдрэл	2.8	3.1	2.9	2.1	2.0	2.6	V
7	Нүд ба дайврын	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	
8	Чих ба хөхөнцрийн	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	
9	Цусны эргэлтийн	44.8	44.5	40.9	42.3	38.6	42.2	I
10	Амьсгалын эрхтний	3.4	4.1	3.8	2.9	2.5	3.4	IV
11	Хоол шингээх	9.8	8.6	10.0	9.1	7.4	9.0	III
12	Арьс ба халимны	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	
13	Яс булчин холбох эдийн	0.3	0.8	0.3	0.1	0.7	0.5	
14	Шээс бэлгэсийн	1.1	1.2	0.6	1.6	2.4	1.4	
15	Жирэмслэлт, төрөх, төрсний дараах	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	
16	Төрөлхийн гажиг	0.0	0.5	0.1	0.2	0.4	0.2	
17	Хаа ч ангилаагүй хам шинж	0.3	0.0	0.0	0.0	0.3	0.1	
18	Бэртэл хордлого	2.9	1.3	1.4	1.3	0.9	1.6	

Эндээс харахад нийт өвчлөлийн эхний 5 байрт Цусны эргэлтийн тогтолцооны өвчин, хавдар, хоол боловсруулах замын өвчин, амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин орж байна.

Мөн Эрүүл мэндийн төвийн хэвтэн эмчлүүлэх тасгаар үйлчлүүлсэн иргэдийг өвчлөлөөр нь авч үзэхэд Цусны эргэлтийн өвчин, хоол боловсруулах замын эмгэг, амьсгалын эрхтэн тогтолцооны өвчлөл их байна.



Орон нутагт эмнэлгийн мэргэжилтэн дутагдалтай, тэдгээрийн тогтвор суурьшил муу, төгсөлтийн дараахь сургалт хангалтгүй, эмч, мэргэжилтний цалин бага, эмнэлэгт байгаа тоног төхөөрөмжийн 80 орчим хувь нь олон жил ашиглагдаж байгаа нь тусламж үйлчилгээний чанарт нөлөөлж байгаа юм.

Иймээс олон нийтийг хамарсан, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эрүүл мэндийн үзлэг, оношлогоог орон нутагт зохион байгуулж хүн амын дунд далд оношлогдохгүй байгаа өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эмчлэн эрүүлжүүлэх нийгмийн эрүүл мэндийг дэмжих дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх шаардлага гарч байна.

#### Хоёр. Дэд хөтөлбөрийн зорилго

Сонгино Хайрхан дүүргийн ард иргэдийг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролын түвшинг нэмэгдүүлэх, БЗДХ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх, осол гэмтлээс сэргийлэх мэдлэгийг дээшлүүлэх, өвчлөлийг эрт илрүүлэн, эрүүлжүүлэх ажлыг хэрэгжүүлэхэд оршино.

#### Гурав. Дэд хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн

3.1. Эрүүл аж төрөх, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх

##### Хүрэх үр дүн:

Эрүүл аж төрөх, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээлэл нэмэгдэж, дүүргийн хүн амын 70% нь эрүүл мэндийн боловсролын хичээлд хамрагдаж, өвчлөл буурсан байна.

3.2. Мэдээлэл, сургалт, сурталчилгааг идэвхжүүлэхэд техник тоног төхөөрөмжөөр хангах

Хүрэх үр дүн:

Сургалтын багийн үйл ажиллагаа тогтмолжсон, сургалтын үйл ажиллагаанд ашиглах тоног төхөөрөмжтэй болсон байна.

3.3. Бэлгийн идэвхитэй амьдралтай, эрсдэлтэй бүлгийн хүмүүст БЗДХ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж, хавьтлыг илрүүлэх замаар тэдний мэдлэгийг нэмэгдүүлэх.

Хүрэх үр дүн:

БЗДХ/ДОХ өвчин буурч, илрүүлэлт, эрүүлжүүлэлт 20%-иар нэмэгдэж, иргэдийн эрүүл мэндийн боловсрол, гэр бүл төлөвлөлтийн мэдлэг сайжирсан байна.

3.4. Сүрьеэ өвчний талаар сургалт, мэдээллээр хангах замаар иргэдийг мэдлэгийг нэмэгдүүлэх, тусламж үйлчилгээг чанаржуулах

Хүрэх үр дүн:

Сүрьеэ өвчний эрт илрүүлэг нэмэгдэж, өвчлөл буурсан байна.

3.5. Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэг шинжилгээ зохион байгуулж, өвчлөлийн түвшинг тогтооно.

Хүрэх үр дүн:

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдагсдын тоо жил бүр 10 хувиар нэмэгдэж, чихрийн шижин, зүрх судас, хавдрын өвчлөл буурсан, эрүүлжилт нэмэгдсэн байна.

Иргэдийн дасгал хөдөлгөөнөөр хичээллэх орчин нэмэгдэж, биеийн тамир, спорт, дасгал хөдөлгөөнөөр хичээллэгсдийн тоо, албан байгууллага, аж ахуйн нэгжийн тоо 5%-иар нэмэгдсэн байна.

Дөрөв: Хэрэгжүүлэх зарчим

4.1. Иргэдийн эрүүл мэндийн байдал, өвчин эмгэгийн төрөл, оршин суугаа газар, нас, хүйс, боловсрол, бэлгийн чиг хандлага, үндэс угсаа, хэл соёлын ялгаанаас үл хамааран эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх

4.2. Үйлчлүүлэгчийн эрхийг дээдэлсэн, тэдний эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцсэн байх

4.3. Төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог хангасан байх

4.4. Дүүргийн хүн ам, нийгэм, эдийн засгийн байдал, орчны нөхцөл болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлт, хэрэгцээ онцлогийг харгалзсан байх.

Тав: Хэрэгжүүлэх хугацаа

Дүүргийн нийгмийн эрүүл мэндийг дэмжих дэд хөтөлбөрийг 2017 оноос 2020 он хүртэл 4 жилийн хугацаатай хэрэгжүүлнэ.

Зургаа: Хамрах хүрээ

Дүүргийн нутгийн захиргааны удирдах байгууллага

Дүүргийн төрийн захиргааны байгууллагууд

Дүүргийн иргэд